

## ТАНИЛЦУУЛГА

*“Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлогыг бүрдүүлэх, цуглуулах, төвлөрүүлэх журам” батлах тухай Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн тогтоолын төсөл*

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн хоёр, гуравдугаар бүлэгт эрүүл мэндийн заавал даатгалд хамрагдах хүн амын бүлэг, тэдгээрийн эрх, үүрэг, эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөх хувь хэмжээ, төлөх журам болон даатгалд хамрагдаж үүргээ бүрэн биелүүлсэн даатгуулагчид үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ болон эрхийг тодорхойлсон. Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлого нь эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын үндсэн эх үүсвэр бөгөөд 2024 оны эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн гүйцэтгэлийг харахад 60.9 хувь буюу 1,170.9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг шимтгэлийн орлогоос төвлөрүүлсэн байна. Үлдэгдэл 39.1 хувийн санхүүжилтийг Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9.1.13 дахь заалтад тусгасан Монгол Улсын иргэний эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлбөрийг төр хариуцах зардлын санхүүжилт болон бусад нэмэлт үйл ажиллагааны орлого эзэлж байна.

*Хүснэгт 1. Эрүүл мэндийн даатгалын сангийн батлагдсан төсөв ба орлогын гүйцэтгэл-2024 он, сая төгрөгөөр*

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
Ажил олгогч, даатгуулагчийн төлөх шимтгэлийн орлого	859,154.8	812,662.2	94.6%
Төр даатгалыг нь хариуцах иргэдийн шимтгэл	324,113.0	324,113.0	100.0%
Төр хариуцах тусламж, үйлчилгээнд улсын төсвөөс олгох санхүүжилт	746,804.8	746,804.8	100.0%
Бусад даатгуулагчийн төлөх шимтгэл	34,684.8	34,155.1	98.5%
Бусад орлого	-	3,989.7	-
<b>Дүн</b>	<b>1,964,757.4</b>	<b>1,921,724.7</b>	<b>97.8%</b>

Эрүүл мэндийн даатгалд 2024 оны 12 дугаар сарын байдлаар 3,274.9 мянган даатгуулагч хамрагдсан. Үүнээс төсөвт байгууллага болон аж ахуй нэгж байгууллагын ажилтан 770.9 мянга, шимтгэлээ өөрөө хариуцан төлдөг иргэд 212.8 мянга, төр хариуцах иргэд 2,291.2 мянга даатгуулагч тус тус хамрагдсан. Монгол Улсын нийт хүн амын тоо 2024 оны жилийн эцсийн байдлаар 3,502.0 мянган иргэн байгаагаас 93.5 хувь нь эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байна. Эрүүл мэндийн

даатгалд хамрагдаж чадаагүй иргэдийн эзлэх хувь өндөр байгааг даатгуулагчийн төрлөөр нь авч үзэхэд тодорхой хөдөлмөр эрхлээгүй иргэд (44.3 хувь буюу 117.8 мянган даатгуулагч хамрагдсан), малчид (36.4 хувь буюу 51.2 мянган даатгуулагч хамрагдсан), их дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн суралцагчид (71.7 хувь буюу 42.5 мянган даатгуулагч хамрагдсан) эрүүл мэндийн даатгалд хамрагдаад байгаа нь голлох нөлөөллийг үзүүлж байна.

*Хүснэгт 2. Эрүүл мэндийн даатгалд хамрагдалтын тоо болон хувь- 2024 он, мянган хүн*

Даатгуулагчийн төрөл	Нийт тоо	Хамрагдсан	Хамрагдалтын хувь	Хамрагдаагүй иргэд
Тодорхой хөдөлмөр эрхлээгүй иргэд	266.2	117.8	44.3%	148.4
Малчид	140.6	51.2	36.4%	89.4
Их дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн суралцагч	59.3	42.5	71.7%	16.8
Гадаадын иргэн, харьяалалгүй иргэд	1.3	1.3	100.5%	0.0
<b>Дүн</b>	<b>467.4</b>	<b>212.8</b>	<b>45.5%</b>	<b>254.6</b>

Эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөх хувь, хэмжээг Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар тогтоодог. Эрүүл мэндийн даатгалын сангийн тэнцлийг хангах, даатгуулагчдын ялгаатай тогтоосон хувь, хэмжээг багасгах зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 02 тоот тогтоолоор эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн 2025 оны хувь, хэмжээг шинэчлэн тогтоосон. Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн зарим хувь, хэмжээг тогтооход ашиглагдаж буй хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нь Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2024 оны 03 дугаар тогтоолоор 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 20 хувиар нэмэгдүүлж сард 792,000.0 төгрөг байхаар тогтоосон.

Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд даатгуулагчийн шимтгэл төлөлттэй холбогдох харилцааг дэлгэрэнгүй зохицуулсан боловч эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлт, тэдгээрийг хэрхэн бүрдүүлэх, цуглуулах, эрүүл мэндийн даатгалын санд төвлөрүүлэх зэрэг хуульд нарийвчлан тусгаагүй үйл ажиллагаанд эрх зүйн зохицуулалтууд нэмэлтээр шаардлагатай байна. Ялангуяа эрүүл мэндийн даатгалд хамрагдах хүн амын бүлэгт яг ямар иргэдийг хамааруулах, нэг иргэн 2-оос дээш бүлэгт зэрэг хамаарсан тохиолдолд аль сонголтоор шимтгэл төлөх, аль хугацаанаас хойш тасралтгүй төлөх, даатгуулагчийн эрүүл мэндийн даатгалд хамрагдалт хангалтгүй байгаа иргэдийг хэрхэн идэвхжүүлэх, нөхөн төлөлт хийх нөхцөл, шаардлага, сонголтуудыг нэмэгдүүлэх, гадаадын иргэн, харьяалалгүй иргэн шимтгэл төлөхөд анхаарах зүйлс зэргийг тодорхой болгох нь чухал байна.

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.8.6 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны 2017 оны 22 дугаар тогтоолоор

баталсан Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн дүрмийн 3 дугаар зүйлийн 3.1.6 дахь заалтуудад Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөл нь эрүүл мэндийн даатгалтай холбогдсон асуудлаар өөрийн бүрэн эрхийн хүрээнд холбогдох журам, тогтоол, зөвлөмж гаргах эрхийг олгосны дагуу эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлогыг бүрдүүлэх, цуглуулах, төвлөрүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахаар журмын төслийг боловсруулав.

Журмын төсөлд Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн шимтгэлтэй холбоотой заалтууд хэрэгжиж эхэлсэн огноо бус (2016 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр) 2019 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ тасралтгүй төлсөн байхыг шаардаж байгаа нь Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар байгуулагдсан огноо (2018 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр), эрүүл мэндийн даатгалын мэдээллийн нэгдсэн сангийн хөгжүүлэлт (2018 он), даатгуулагчид очих санхүүгийн дарамт зэргээс шалтгаалсан. Хэрвээ Эрүүл мэндийн даатгалын тухай хууль хэрэгжиж эхэлсэн 2016 оноос хойш нөхөн төлж буй тохиолдолд эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлж буй иргэд нийт 1,037.5 мянган төгрөг төлөх бол 2019 оноос эхлэн тооцон төлөхөд уг дүн 285.1 мянган төгрөгөөр бага буюу 752.4 мянган төгрөг болж буурахаар байна. Эрүүл мэндийн салбарын шинэчлэл эхэлсэн 2021 оноос эхлэн эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ нөхөн төлж буй бол нийт төлбөрийн хэмжээ 562.3 мянган төгрөг байгаа нь 2016 оноос эхлэн төлөх төлбөрийн хэмжээтэй харьцуулахад 475.2 мянган төгрөгөөр бага байна.

Хүснэгт 3. Эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлтийн хэмжээ, 2016-2025 он

Он	ХХДХ	Шимтгэл тооцох сарын хувь	ЭМД-ийн шимтгэл /жилээр/	Тогтоолын төсөлд	Зөрүү буюу торгууль, алданги	Хувь
2016 он	192,000.0	1.0%	23,040.0	95,040.0	72,000.0	312.5%
2017 он	240,000.0	1.0%	28,800.0	95,040.0	66,240.0	230.0%
2018 он	240,000.0	1.0%	28,800.0	95,040.0	66,240.0	230.0%
2019 он	320,000.0	1.0%	38,400.0	95,040.0	56,640.0	147.5%
2020 он	420,000.0	1.0%	50,400.0	95,040.0	44,640.0	88.6%
2021 он	420,000.0	1.0%	50,400.0	95,040.0	44,640.0	88.6%
2022 он	420,000.0	1.0%	50,400.0	95,040.0	44,640.0	88.6%
2023 он	550,000.0	1.0%	66,000.0	95,040.0	29,040.0	44.0%
2024 он	660,000.0	1.0%	79,200.0	95,040.0	15,840.0	20.0%
2025 он	792,000.0	2.0%	182,160.0	182,160.0	-	0.0%
			<b>597,600.0</b>	<b>1,037,520.0</b>	<b>439,920.0</b>	<b>73.6%</b>

Хувилбар	Тайлбар	Тухайн үеийн ханшаар	Тогтоолын төсөлд	Зөрүү буюу торгууль, алданги	Хувь
Хувилбар 1	Хуулийн заалт хэрэгжсэн хугацаанаас тооцож үзэхэд	597,600.0	1,037,520.0	<b>439,920.0</b>	73.6%

Хувилбар 2	2019 он буюу ЭМДЕГ байгуулагдаж, систем шинэчилсэн үеэс тооцож үзэхэд	516,960.0	752,400.0	<b>235,440.0</b>	45.5%
	<b>Зөрүү</b>	<b>80,640.0</b>	<b>285,120.0</b>	<b>204,480.0</b>	
Хувилбар 3	2021 он буюу эрүүл мэндийн салбарын шинэчлэл эхэлсэн үеэс тооцож үзэхэд	428,160.0	562,320.0	<b>134,160.0</b>	31.3%
	<b>Зөрүү</b>	<b>169,440.0</b>	<b>475,200.0</b>	<b>305,760.0</b>	

Мөн журмын төсөлд эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ хугацаанд төлөөгүй бол торгууль, алданги хэлбэрээр төлөлт хийгдээгүй оны хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ бус төлөлт хийж буй үед хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр төлүүлэхээр тусгасан.

Тус Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн тогтоол батлагдсанаар хуулиар нарийвчлан зохицуулаагүй харилцааг тодорхой болгох, эрүүл мэндийн даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэх, эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлттэй холбоотой мэдээлэл солилцооны эрх зүйг бүрдүүлэх, даатгуулагчийн үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх зэрэг ач холбогдолтой болно.

## ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

## ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

### Журам батлах тухай

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.8.6 дахь заалт, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн дүрмийн 3 дугаар зүйлийн 3.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлогыг бүрдүүлэх, цуглуулах, төвлөрүүлэх журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар /С.Энхболд/-т үүрэг болгосугай.

2.1. Хүн амыг эрүүл мэндийн даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэх нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах, эрүүл мэндийн даатгалын тухай хууль тогтоомж, эрүүл мэндийн даатгалын ач холбогдлыг олон нийтэд сурталчлах ;

2.2. Даатгуулагчид эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ хялбар төлөх боломжийг бүрдүүлэх;

2.3. Даатгуулагчдын шимтгэл төлөлтийн мэдээллийг холбогдох байгууллагуудтай солилцох, нэгдсэн мэдээллийн сан үүсгэх;

2.4. Шимтгэл төлөлттэй холбоотой мэдээллийг иргэдэд ил тод, хүртээмжтэй, ойлгомжтой хэлбэрээр хэрэгжүүлэх;

2.5. Хүн амыг эрүүл мэндийн даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэх, шимтгэлийн орлогыг бүрдүүлэх, мэдээлэл солилцох чиглэлээр нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, улсын бүртгэлийн байгууллага, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, гэрээт эрүүл мэндийн байгууллагууд, санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд болон орон нутгийн засаг захиргааны байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ байгуулах;

2.6. Аймаг, сумын аварга малчин өрх, аймгийн хошой аварга малчин өрх, аймаг, сумын аварга фермер, мянгат малчин тодруулах болон төрөөс олгож буй хөнгөлөлттэй зээл, урамшуулалд хамрагдах аж ахуй нэгж, байгууллага,

иргэний шалгуур үзүүлэлтэд эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ төлсөн иргэдийг хамруулах эрх зүйн орчныг бүрдүүлэхэд холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах;

2.7. Эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлтийн үзүүлэлтүүд, хэрэгжүүлсэн ажлын үр дүн, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг даатгуулагчийн төрөл тус бүрээр нэгтгэж байгууллага болон албан хаагчдад урамшуулал олгох саналыг жил бүрийн эхний улиралд багтаан Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (С.Төгсдэлгэр)-т, тогтоолыг холбогдох хууль тогтоомжийн дагуу Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлж ажиллахыг ажлын албаны дарга /Ц.Сарантуяа/-д даалгасугай.

ДАРГА

Т.МӨНХСАЙХАН

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН  
ОРЛОГЫГ БҮРДҮҮЛЭХ, ЦУГЛУУЛАХ, ТӨВЛӨРҮҮЛЭХ  
ЖУРАМ**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Энэхүү журмын зорилго нь эрүүл мэндийн даатгалын шимтгэл (цаашид “шимтгэл” гэх)-ийн орлогыг холбогдох хууль болон тогтоолуудын дагуу бүрдүүлэх, хэрэгжилтийг хангах, түүнд хяналт тавих, шимтгэл төлөх сонголтыг бий болгох, ил тод байдлыг хангах, хүн амын эрүүл мэндийн даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. Шимтгэлийн орлогод даатгуулагчийн төлсөн шимтгэл, ажил олгогчийн төлсөн шимтгэл, төр даатгалыг нь хариуцах иргэдэд улсын төсвөөс төлсөн шимтгэлийн орлогууд хамаарна.

1.3. Даатгуулагчийн бүрэн хамралт (цаашид “бүрэн хамралт” гэх) гэж даатгуулагч өөрөө төлөх эсвэл ажил олгогчтой хамтран төлөх шимтгэлээ холбогдох хууль, журамд заасан албан журмын даатгалын шимтгэлийн хувь хэмжээгээр 2019 оноос хойш тасралтгүй, хугацаанд нь төлснийг хэлнэ.

**Хоёр. Шимтгэл төлөлт хийх даатгуулагчдын төрөл**

2.1. Иргэн шимтгэлээ 2019 оны 1 дүгээр сараас хойших хугацаанд холбогдох хууль болон Засгийн газрын тогтоолд заасан хувь, хэмжээ, үүргийн дагуу бүрэн гүйцэд төлсөн тохиолдолд эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багцад хамаарах тусламж, үйлчилгээг эрүүл мэндийн даатгалын байгууллагатай гэрээ бүхий эрүүл мэндийн байгууллагаас авахдаа холбогдох Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн тогтоолд заасны дагуу хөнгөлөлтийг эдлэх ба сүүлийн нэг сарын шимтгэл ногдуулалт хамаарахгүй.

2.2. Даатгуулагч, ажил олгогч тэнцүү хувь хэмжээгээр сар бүр төлөх даатгуулагчид нийгмийн даатгалын шимтгэлүүдийг албан журмаар төлж буй ажилтнууд хамаарна.

2.3. Иргэн өөрөө хариуцан сар, улирал, хагас жил, эсхүл бүтэн жилээр шимтгэл төлөх даатгуулагчид дараах иргэн хамаарна:

- 2.3.1. Хувиараа хөдөлмөр эрхлэгч;
- 2.3.2. Малчин;
- 2.3.3. Өөрөө хүсэлтээр даатгуулж буй гадаадын иргэн, харьяалалгүй хүн;
- 2.3.4. Монгол улсын болон гадаад улсын иргэний харьяалалтай 19 болон түүнээс дээш насны их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн суралцагч;
- 2.3.5. Тодорхой ажил хөдөлмөр эрхэлдэггүй иргэн;
- 2.3.6. Тэтгэвэр авагч гадаадын иргэн, харьяалалгүй хүн;
- 2.3.7. 0 сараас 18 нас 12 сар 31 хоногтой гадаадын иргэн, харьяалалгүй хүүхэд;

2.4. Малчдын шимтгэлийг баг, хорооны Засаг дарга нар хариуцан даатгагчтай байгуулсан гэрээний дагуу иргэн бүрээр төлүүлнэ.

2.5. 19 болон түүнээс дээш насны их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн суралцагчийн шимтгэлийг сургуулийн захиргаа хариуцан суралцагч бүрээр хичээлийн жилийн сургалтын төлбөр дээр нэмж авах байдлаар төлүүлнэ.

2.6. Энэхүү журмын 2.3 дахь хэсэгт заасан иргэдэд эрүүл мэндийн даатгалын тухай хууль тогтоомж, эрүүл мэндийн даатгалын ач холбогдлыг эрүүл мэндийн даатгалын байгууллага сурталчлан танилцуулахад эрүүл мэндийн даатгалын байгууллагатай гэрээ бүхий бүх эрүүл мэндийн байгууллагууд болон аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, нийгмийн эрүүл мэндийн төвүүд хамтран ажиллана.

2.7. Даатгуулагчийн шимтгэлийг улсын төсвөөс сар бүр төлөх даатгуулагчид дараах иргэн хамаарна:

- 2.7.1. 0 сараас 18 нас 12 сар 31 хоногтой хүүхэд;
- 2.7.2. Өндөр насны тэтгэврээс өөр тогтмол мөнгөн орлогогүй иргэн;
- 2.7.3. Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэврээс өөр тогтмол мөнгөн орлогогүй иргэн;
- 2.7.4. Тэжээгчээ алдсаны тэтгэврээс өөр тогтмол мөнгөн орлогогүй иргэн;
- 2.7.5. Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн;
- 2.7.6. Хүүхдээ хоёр нас хүртэл нь өсгөн бойжуулж байгаа эх эсхүл эцэг;
- 2.7.7. 2 болон түүнээс дээш ихэр хүүхдээ гурван нас хүртэл нь өсгөн бойжуулж байгаа эх эсхүл эцэг;
- 2.7.8. Хугацаат цэргийн жинхэнэ албан хаагч;

2.8. Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд Нийгмийн халамжийн тухай хуульд заасан Үндэсний



статистикийн хороо, нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран баталсан аргачлалын дагуу өрхийн мэдээллийн нэгдсэн санд орсон, амьжиргааны түвшин нь тухайн үеийн ядуурлын шугамаас доогуур өрхөөс сонгогдсон өрхийн гишүүнийг хамааруулна.

2.9. 0 сараас 18 нас 12 сар 31 хоногтой хүүхэд нь нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн эсхүл ял эдэлж буй хүүхэд бол энэхүү журмын 2.7.1 дэх заалтын дагуу шимтгэлийг улсын төсвөөс төлнө.

2.10. Өндөр насны тэтгэвэр, хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр, тэжээгчээ алдсаны тэтгэврээс өөр тогтмол мөнгөн орлогогүй иргэн нь нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн эсхүл малчин бол энэхүү журмын 2.7.2, 2.7.3, 2.7.4 дэх заалтуудын аль тохирохоор шимтгэлийг улсын төсвөөс төлнө.

2.11. Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн хүүхдээ өсгөн бойжуулж байгаа эх, эцгийн аль нэгний шимтгэлийг энэхүү журмын 2.7.5 дахь заалтын дагуу улсын төсвөөс төлнө.

2.12. Хүүхдээ өсгөн бойжуулж байгаа эх эсвэл эцэг хоорондоо солигдож буй тохиолдолд нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын шийдвэрийн мэдээлэлд үндэслэн шимтгэлийг улсын төсвөөс төлнө.

2.13. Хүүхдээ өсгөн бойжуулж байгаа эх эсхүл эцэг нь ажилдаа эргэн орсон тохиолдолд зөвхөн энэхүү журмын 2.2 дахь хэсэгт заасны дагуу шимтгэлийг төлөх ба буцаж хүүхдээ өсгөн бойжуулж байгаа бол дахин тогтоосон хугацаанаас эхлэн нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын шийдвэрийн мэдээлэлд үндэслэн шимтгэлийг улсын төсвөөс төлнө.

2.14. Хугацаат цэргийн албан хаагчдын шимтгэлийг алба хааж эхэлснээс халагдах хүртэлх хугацаанд харьяалах цэргийн анги, нэгтгэл хариуцан улсын төсвөөс төлнө.

2.15. Шүүхийн шийдвэрийн дагуу ял эдэлж буй ялтны шимтгэлийг хорих байгууллага нийгмийн даатгалын сангаар дамжуулан төлнө.

### **Гурав. Гадаадын иргэн, харьяалалгүй хүний шимтгэл төлөлт**

3.1. Монгол улсад амьдарч буй гадаадын иргэн, харьяалалгүй хүн нь өөрийн хүсэлтээр даатгуулж буй тохиолдолд төлөлт хийсэн хугацаанаас хойш 6 сарын дараа эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг эрүүл мэндийн байгууллагаас авах эрх үүснэ.

3.2. Гадаадын иргэн, харьяалалгүй хүн нь шимтгэл төлөлтөө 1-ээс дээш сараас тасалдуулсан тохиолдолд сар тутамд 5 хувийн алданги төлнө.

3.3. Гадаадын иргэн, харьяалалгүй хүн нь гэр бүлийн гишүүдийн хамтаар шимтгэлээ бүрэн төлнө.

3.4. Энэхүү журмын 2.7 дахь хэсэгт заасан даатгуулагчид гадаадын иргэн, харьяалалгүй хүн хамаарахгүй.

### **Дөрөв. Шимтгэлийн нөхөн төлөлттэй холбоотой зохицуулалт**

4.1. Энэхүү журмын 2.3 дахь хэсэгт заасан даатгуулагч журмын 2.1 дэх хэсэгт заасан шаардлагыг бүрэн хангаагүй тохиолдолд тухайн даатгуулагч шимтгэлийн нөхөн төлөлтийг заавал хийх бөгөөд ингэхдээ төлөлт хийж буй үеийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, түүнтэй адилтгах орлого, түүнд ногдуулсан Засгийн газрын тогтоолын дагуух шимтгэлийн хувь хэмжээгээр тооцож төлнө.

4.2. Даатгуулагчийн шимтгэл төлөлт хугацааны хувьд даатгуулагчийн нэг төрлөөр тухайн сард давхар төлөгдсөн тохиолдолд эрүүл мэндийн даатгалын байгууллага тухайн даатгуулагчийн гаргасан хүсэлтэд үндэслэн өглөг үүсгэж даатгуулагчийн дараагийн саруудын шимтгэлийн хэмжээнээс хасагдуулаг хийж өглөгийг барагдуулна.

4.3. Даатгуулагч шимтгэлээ нөхөн төлснөөс хойш 3 сарын дотор эрүүл мэндийн даатгалын байгууллагатай гэрээт эрүүл мэндийн байгууллагаас Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9.1.13 дахь заалтад зааснаас бусад тусламж, үйлчилгээг авч буй тохиолдолд Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн тогтоолуудаар баталсан хамтын төлбөрийн нийт хэмжээнээс нөхөн төлөлт хийж буй хугацаатай уялдуулан дараах хувиар хамтын төлбөр төлнө.

4.3.1. 16 хүртэлх сарын даатгуулагчийн шимтгэлээ нөхөн төлж буй тохиолдолд нийт төлбөрийн 25 хувиар;

4.3.2. 16-36 сарын даатгуулагчийн шимтгэлээ нөхөн төлж буй тохиолдолд нийт төлбөрийн 35 хувиар;

4.3.3. 37-с дээш сарын сарын даатгуулагчийн шимтгэлээ нөхөн төлж буй тохиолдолд нийт төлбөрийн 50 хувиар;

4.4. Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн тогтоолуудаар баталсан даатгуулагчаас авах хамтын төлбөрийн хэмжээ 20 хувиас дээш эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд энэхүү журмын 4.3 дахь хэсэгт заасан хязгаарлалтууд хамаарахгүй.

4.5. Гадаад улсад сурч, ажиллаж байсан иргэд гадаад улсад сурч, ажилласан хугацааны шимтгэл төлөлтөөс чөлөөлөгдөхгүй.

### **Дөрөв. Шимтгэл төлөх хэлбэр**

5.1. Энэхүү журмын 2.2 дахь хэсэгт заасан даатгуулагчийн шимтгэлийг нийгмийн даатгалын санд ажил олгогч төвлөрүүлнэ.

5.2. Нийгмийн даатгалын байгууллага нь Нийгмийн даатгалын санд хуримтлагдсан шимтгэлийн орлогыг эрүүл мэндийн даатгалын байгууллагатай байгуулсан хамтран ажиллах гэрээний дагуу эрүүл мэндийн даатгалын санд бүрэн шилжүүлнэ.

5.3. Энэхүү журмын 2.3 дахь хэсэгт заасан даатгуулагчид шимтгэлийн төлбөрийг цахим эсвэл арилжааны банкаар дамжуулан гүйлгээ хийх хэлбэрээр төлнө.

5.4. Цахим гүйлгээнд эрүүл мэндийн даатгалын сангийн Төв төрийн сангийн данс руу арилжааны банкнуудын аппликейшн болон интернэт банк, E-Mongolia, E-barimt платформ, киоск төхөөрөмж, эрүүл мэндийн даатгалын байгууллагын цахим хуудас, аппликейшн болон бусад ижил төрлийн үйлчилгээг ашиглан хийх гүйлгээг хамааруулна.

5.5. Киоск төхөөрөмж ашиглан шимтгэл төлж буй тохиолдолд киоск үйлчилгээ үзүүлэгч байгууллага нь эрүүл мэндийн даатгалын байгууллагатай хийсэн хамтран ажиллах гэрээний дагуу даатгуулагчаас нэмэлт төлбөр, хураамж авч болно.

5.6. Киоск үйлчилгээний нэмэлт төлбөр, хураамжийг даатгуулагчийн сайн дурын үндсэн дээр эрүүл мэндийн даатгалын сан болон эрүүл мэндийн даатгалын байгууллагын дансанд төвлөрүүлэхгүй байдлаар гэрээлж хэрэгжүүлнэ.

5.7. Цахим гүйлгээгээр шимтгэл төлөх боломжгүй тохиолдолд арилжааны банкаар гүйлгээ хийж төлбөрийн баримтыг эрүүл мэндийн даатгалын байгууллагад өгч шимтгэлийн орлогын ногдуулалт хийлгэнэ.

5.8. Даатгуулагчийн шимтгэлийг улсын төсвөөс хариуцан төлөхдөө дараах байгууллагуудаас ирүүлсэн даатгуулагчийн мэдээлэлд үндэслэн гаргасан эрүүл мэндийн даатгалын байгууллагын нэхэмжлэлийн дагуу хяналтыг хийж сар бүрийн 5-ны өдрийн дотор эрүүл мэндийн даатгалын санд эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас шилжүүлнэ:

5.8.1. Энэхүү журмын 2.7.1 дэх заалтад тусгасан даатгуулагчийн шимтгэлийг улсын бүртгэлийн байгууллагаас ирүүлсэн хүн амын мэдээлэл болон шинээр төрсөн, эндсэн хүүхдийн мэдээлэлд үндэслэн нэхэмжилнэ;

5.8.2. Энэхүү журмын 2.7.2-2.7.4 дэх заалтуудад тусгасан даатгуулагчийн шимтгэлийг нийгмийн даатгалын болон нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас ирүүлсэн тэтгэвэр авагчдын мэдээлэлд үндэслэн нэхэмжилнэ;

5.8.3. Энэхүү журмын 2.7.5 дахь заалтад тусгасан даатгуулагчийн шимтгэлийг нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас ирүүлсэн иргэдийн мэдээлэлд үндэслэн нэхэмжилнэ;

5.8.4. Энэхүү журмын 2.7.6-2.7.8 дахь заалтад тусгасан даатгуулагчийн шимтгэлийг нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас ирүүлсэн иргэдийн мэдээлэлд үндэслэн нэхэмжилнэ;

5.9. Энэхүү журмын 2.15 дахь хэсэгт тусгасан даатгуулагчийн шимтгэлийг ял эдэлж буй ялтан бүрээр сар бүрийн 10-ны өдрийн дотор эрүүл мэндийн даатгалын санд нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас шилжүүлнэ.

### **Зургаа. Шимтгэл төлөлтийн мэдээлэл солилцоо**

6.1. Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь дараах мэдээллийг холбогдох байгууллагуудаас бодит цагийн горимоор цахим хэлбэрээр хүлээн авч эрүүл мэндийн даатгалын мэдээллийн санд нэгтгэн даатгуулагчийн шимтгэл төлөлтийн мэдээллийг тогтмол шинэчилнэ:

6.1.1. Ажил олгогч, ажилтнаас тухайн улиралд төлсөн даатгуулагчийн мэдээллийг тайлагналт хийсэн сар бүрээр нийгмийн даатгалын мэдээллийн сангаас авна;

6.1.2. Нас барсан болон шинээр өндөр насны тэтгэвэр, хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр, тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгосон иргэдийн мэдээллийг нийгмийн даатгалын мэдээллийн сангаас авна;

6.1.3. Хүүхдээ өсгөн бойжуулж байгаа эх эсхүл эцгийн даатгуулагчийн мэдээллийг нийгмийн даатгалын мэдээллийн сангаас авна;

6.1.4. Шинээр төрсөн хүүхдийн даатгуулагчийн мэдээллийг эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн сангаас авна;

6.1.5. Монгол улсын нийт хүн амын дэлгэрэнгүй мэдээллийг иргэний улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сангаас авна. Тус дэлгэрэнгүй мэдээллийг эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй иргэн, 19 нас хүрч даатгуулагчийн шимтгэлийг улсын төсвөөс хариуцахгүй болох иргэн, өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн нэг иргэнээр тооцсон санхүүжилтийг хэмжээг

тодорхойлох болон бусад эрүүл мэндийн даатгалын сангийн судалгаа, тооцоололд ашиглана;

6.1.6. Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэний мэдээллийг нийгмийн халамжийн нэгдсэн сангаас авна;

6.1.7. 19 болон түүнээс дээш насны их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн суралцагчдын нийт тоог боловсролын цахим мэдээллийн сангаас авна;

6.1.8. Хугацаат цэргийн албан хаагчдын мэдээллийг нийгмийн даатгалын мэдээллийн сангаас авна;

6.1.9. Ял эдэлж буй ялтны мэдээллийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас авна;

6.2. Даатгуулагчийн мэдээллийн өгөгдлийг эрүүл мэндийн даатгалын байгууллага энэхүү журмын 6.1 дэх хэсэгт заасан байгууллагуудтай хамтран ажиллах гэрээний дагуу дамжуулна.

6.3. Төрийн байгууллага хооронд даатгуулагчийн мэдээллийг дамжуулахдаа Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Төрийн болон албаны нууцын тухай хууль болон бусад эрх зүйн актуудын дагуу шаардлагыг хангаж ажиллана.

6.4. Нийт даатгуулагчдын мэдээллийг бодит цагийн горимоор эрүүл мэндийн байгууллагууд харахаар программ хангамжийг хөгжүүлнэ.

### **Долоо. Бүрэн хамралт бүхий даатгуулагчид үзүүлэх хөнгөлөлт**

7.1. Бүрэн хамралт бүхий даатгуулагч сүүлийн 3 жилийн хугацаанд эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ аваагүй тохиолдолд урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамруулах урилгыг нэн тэргүүнд хүргүүлнэ.

7.2. Бүрэн хамралт бүхий даатгуулагч нь эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багцад хамаарах тусламж, үйлчилгээг эрүүл мэндийн даатгалын байгууллагатай гэрээ бүхий эрүүл мэндийн байгууллагаас авч буй тохиолдолд холбогдох Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн тогтоолд заасан тусламж, үйлчилгээний төрөл<sup>1</sup> тус

---

<sup>1</sup> Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн тогтоолоор баталсан “Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний оношийн хамааралтай бүлгийн жагсаалт, төлбөрийн хэмжээ”-д тусгасан тусламж, үйлчилгээний төрөл тус бүрд хамаарна.

бүрээр авсан эхний тусламж, үйлчилгээнд тогтоосон хамтын төлбөрийн хэмжээнээс 3 жил тутам 50 хувиар хөнгөлнө.

### **Найм. Бусад**

8.1. Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан харьяа хүн амын эзлэх хувь улсын дунджаас өндөр байгаа болон шинээр эрүүл мэндийн даатгалд хамруулсан иргэдийн тоог үндэслэн орон нутгийн эрүүл мэндийн газар, эрүүл мэндийн даатгалын байгууллагын салбарууд, анхан шатлалын эрүүл мэндийн байгууллага, баг, хорооны засаг захиргааны нэгж, боловсролын байгууллагад эрүүл мэндийн даатгалын сангаас Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн тогтоолуудтай уялдуулан нэмэлт мөнгөн урамшуулал олгож болно.

8.2. Нэмэлт мөнгөн урамшууллыг шинээр даатгалд хамруулсан иргэн тутамд олгох урамшууллын хэмжээгээр тооцох бөгөөд тус урамшууллын хэмжээг эрүүл мэндийн даатгалын сангийн тухайн жилийн батлагдсан төсөвтэй уялдуулан Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн тогтоолоор батална.

8.3. Даатгуулагчийн шимтгэл төлөлтийн тасалдаж буй хугацаа, төлөх шаардлагатай шимтгэл төлөлтийн хэмжээ, төлөлт хийх огнооны хязгаарын тухай анхааруулах мэдээллийг даатгуулагчийн бүртгэлтэй гар утасны дугаар эсхүл цахим хаягаар эрүүл мэндийн даатгалын байгууллага тухайн даатгуулагчид илгээнэ.

8.4. Даатгуулагч нь шимтгэл төлөлтийг эрүүл мэндийн даатгалын байгууллагын ажилтнаар дамжуулан хийхийг хориглоно.

8.5. Эрүүл мэндийн даатгалын мэдээллийн сангийн хариуцах болон ашиглах чиг үүрэг бүхий ажилтан нь албан үүргийн дагуу олж авсан мэдээллийг хувийн зорилгоор ашиглах болон гуравдагч этгээдэд дамжуулахыг хориглоно.

8.6. Шимтгэл төлөлттэй холбоотой даатгуулагчид хохирол учирсан тохиолдолд хохирлыг буруутай эдгээд барагдуулна.

8.7. Уг журмыг зөрчсөн тохиолдолд холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

## ТЭМДЭГЛЭЛ

### **Засгийн газрын 2022 оны 8 дугаар тогтоолд**

УЛСЫН АВАРГА МАЛЧИН ӨРХ, УЛСЫН ХОШОЙ АВАРГА МАЛЧИН ӨРХ ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ-ын “2.1.13. малчин нь нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд даатгуулж, малын индексжүүлсэн даатгалд малаа даатгуулсан байх.”

“УЛСЫН АВАРГА ФЕРМЕР” ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ-ын “2.1.2. мал, амьтныг эрсдэлээс хамгаалах даатгалд хамруулж, холбогдох хууль тогтоомжийн дагуу татвар, хураамж, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл тогтмол төлсөн байх;”

УЛСЫН АВАРГА СААЛЬЧИН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ-д зөвхөн бүрдүүлэх материал дунд нь эрүүл мэндийн даатгалын төлөлтийн тодорхойлолт орсон.

Засгийн газрын 2021 оны 5 дугаар тогтоолд

УЛСЫН АВАРГА ТАРИАЛАНЧ ХАМТ ОЛОН, УЛСЫН АВАРГА ТАРИАЛАНЧ ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ-ын “2.1.9. татвар, хураамж болон газрын төлбөрийг хугацаанд нь төлсөн байх;”

Аймгийн аварга малчин, тариаланч, фермер болон мянгат малчин шалгаруулах журмыг аймаг, сумын иргэдийн хурал, засаг дарга баталж байна. Тусгайлсан жишиг журам байхгүй.

**ГЭР БҮЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН** “3.1.4. “гэр бүлийн гишүүн” гэж гэрлэгчид, тэдэнтэй хамт амьдарч байгаа төрсөн, дагавар, үрчлэн авсан хүүхэд болон төрөл, садангийн хүнийг;” хэлнэ.

**ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ** хуулийн 3.1.9. “малчин” гэж мал аж ахуй эрхэлж үндсэн орлогоо олдог иргэнийг хэлнэ.

### **ГАДААДЫН ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ**

5.1.1. “гадаадын иргэн” гэж Монгол Улсын иргэний харьяалалгүй бөгөөд гадаад улсын иргэний харьяалалтай хүнийг;

5.1.7. “харьяалалгүй хүн” гэж аль ч улсын харьяат бус хүнийг;